


# "ХАЛХЫН ГОЛ-1939"

## Архивын баримт бичиг, гэрэл зураг, баримтат киноны үзэсгэлэн

## Выставка архивных документов и фотографий



1939 он. Халхын гол.
Монгол ардын хувьсгалт цэргийн байлдагч М.Дорж, Ажилчин тариачны улаан армийн ахлах дэслэгч В.А.Васильев нар

Солдат Монгольской народно-революционной армии М.Дорж и старший лейтенант Красной армии рабочих и крестьян В.А.Васильев



Халхын голын дайны ахмад дайчин М.Дорж ач охины хамт

Ветеран войны Халхин-Гола М.Дорж вместе с внучкой

АРХИВЫН ЕРӨНХИЙ ГАЗАР МОНГОЛ УЛС

Улаанбаатар
2019




### Зохион байгуулагч: / Организаторы:

Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн яам — Министерство юстиции и внутренних дел Монголии

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Архивын ерөнхий газар — Главное архивное управление Монголии

Оросын Холбооны Улсын Холбооны архивын агентлаг — Федеральное архивное агентство Российской Федерации

### Хамтран зохион байгуулагч: / Участники выставки:

Монгол Улсын Батлан хамгаалах яам — Министерство обороны Монголии

Монгол Улсын Гадаад харилцааны яам — Министерство внешних сношений Монголии

Оросын түүхийн нийгэмлэг — Российское историческое общество

# Халхын голын баатрууд
# Герои Халхин-Гола


Г.К.Жуков


Я.В.Смушкевич


И.М.Ремизов


М.П.Яковлев


Ж.Лхагвасүрэн


Л.Дандар


Ш.Гонгор


П.Чогдон

АРХИВЫН ЕРӨНХИЙ ГАЗАР МОНГОЛ УЛС



Перед войной

I.

Хал-Хин-Гол.

В 1939 году Советское правительство, выполняя взятое на себя обязательство от 12 марта 1936 года, оказало Монгольской Народной Республике военную помощь в разгроме японских войск, вторгшихся на территорию дружественной нам Монгольской Народной Республики в районе реки Хал-Хин-Гол.
С мая по 15 сентября 1939 года, на территории М.Н.Р. происходили ожесточенные сражения между советско-монгольскими и японо-маньчжурскими войсками.
С японской стороны в их военной авантюре участвовала 6ª японская армия, сформированная из отборных японских оккупационных войск Квантунской армии, расположенной в Китае.
Со стороны советских и монгольских войск в начале боевых действий участвовали отдельные части М.Н.Р. поддержанные частями 57ᵒ отдельного корпуса Красной армии, дислоцированного на территории Монгольской Народной Республики.
Генеральную операцию по окружению и полному разгрому 6ª японской армии проводила 1ª армейская группа, развернутая на базе 57 о.к. при содействии группы войск М.Н.Р.
Чтобы завуалировать свою агрессивную цель вторжения в М.Н.Р., японское правительство поручило квантунским военным властям задуманную агрессию преподнести мировой общественности в виде пограничного конфликта.
Для большей убедительности, в начале боевых действий, сразу не вводя в дело большие силы, начав вторжение [illegible]

**1969 он**

- Маршал Г.К.Жуковын “Дуртгал бодол” зохиолын “Халхын голын дайн” хэмээх 7 дугаар бүлгийн гар бичмэл эх.
- Рукопись 7-й главы “Война на Халхин-Голе” из мемуарного труда маршала Г.К.Жукова “Воспоминания и размышления”.

*РГВА.Ф41107.Оп1.Д.8.Л.1-2*



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2018 оны 7 дугаар сарын 4-ний өдөр — Улаанбаатар хот

Дугаар 210
ОЙ ТЭМДЭГЛЭХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Ахмад дайчдын гавьяа, зүтгэлийг алдаршуулан мөнхжүүлэх, Оросын Холбооны Улстай тогтоосон найрсаг харилцаа, хамтын ажиллагаа, ард түмний харилцан ойлголцлыг бэхжүүлэх зорилгоор Халхын голын 1939 оны байлдааны ялалтын 80 жилийн ойг 2019 онд тэмдэглэсүгэй.

2. Халхын голын 1939 оны байлдааны ялалтын 80 жилийн ойд бэлтгэх, зохион байгуулах хорооны бүрэлдэхүүнийг 1 дүгээр хавсралт, ойд бэлтгэх, тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2 дугаар хавсралт ёсоор тус тус батлагтугай. (Энэ тогтоолын 1 дүгээр хавсралтад Засгийн газрын 2018 оны 269 дүгээр тогтоолоор нэмэлт орсон)

3. Халхын голын 1939 оны байлдааны ялалтын 80 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээнд шаардагдах хөрөнгийг Батлан хамгаалахын сайдын 2019 оны төсвийн багцад тусган санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Батлан хамгаалахын сайд Н.Энхболд, Сангийн сайд Ч.Хүрэлбаатар нарт даалгасугай.

| | |
|---|---|
| Монгол Улсын Ерөнхий сайд | У.ХҮРЭЛСҮХ |
| Батлан хамгаалахын сайд | Н.ЭНХБОЛД |

**2018.07.04**

- Халхын голын байлдааны 80 жилийн ойг тэмдэглэх тухай Монгол Улсын Засгийн газрын 210 дугаар тогтоол.
- Постановление №210 Правительства Монголии о праздновании 80-й годовщины победы битвы на Халхин-голе.



**1989 он**

- Халхын голын дайны ялалтын 50 жилийн ойд уригдан ирсэн ЗСБНХУ-ын дөрвөн удаагийн болон БНМАУ-ын баатар Г.К.Жуковын охид Халхын гол дахь Зөвлөлт, Монголын дайчдын хөшөөнд хүндэтгэл үзүүлээд явж буй нь.

*МУУТА, КГЗДАБА-ын сан хөмрөгөөс*

- Дочери Четырежды Героя Советского Союза и Героя МНР Г.К.Жукова, прибывшие на празднование 50-й годовщины победы войны на Халхин-Голе у памятника советско-монгольским войнам.



**1989 он**

- Халхын голын дайны ялалтын 50 жилийн ойгоор МАХН-ын Төв Хорооны Ерөнхий нарийн бичгийн дарга, БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчдийн дарга Ж.Батмөнх Халхын голын дайны ахмад дайчдын хамт.

*МУУТА, КГЗДАБА-ын сан хөмрөгөөс*

- Генеральный секретарь ЦК МНРП и Председатель Президиума ВНХ МНР Ж.Батмунх вместе с ветеранами Халхин Гола на торжествах 50-й годовщины победы.



## МЭНДЧИЛГЭЭ



Монголын ард түмний үндэсний тусгаар тогтнолоо батлан хамгаалах зэвсэгт тэмцлийн түүхэнд Халхын голын дайны ялалт онцгой хүндтэй байр суурь эзэлнэ.

1930-аад онд Ази тивийн Хятад, Манжуур, Монголын талаарх их гүрнүүдийн геополитикийн зөрчил гүнзгийрч, 1935 онд Япон-Манжийн цэргүүд БНМАУ-ын “Халхын сүм”-ийг эзэлснээр “БНМАУ-Манжго улсын хилийн будлиан” гэгчийг үүсгэж, 1939 оны 5 дугаар сард Япон-Манжийн цэргийн томоохон хүчин БНМАУ-ын нутагт халдан довтолсноор Халхын голын дайн үүссэн түүхтэй.

Монгол-Зөвлөлтийн цэргийн хамтарсан хүчин 1939 оны 8 дугаар сарын 20-31-нд Японы Квантуны 6 дугаар армийг бүслэн бутцохиж, түүхэн ялалтыг байгуулсан.

Халхын голын ялалт нь Монгол, Зөвлөлтийн ард түмний найрамдал нөхөрлөлийг бататган, хоёр орны цэргийн хамтын ажиллагааг шинэ шатанд гаргаж, БНМАУ-ын үндэсний тусгаар тогтнолыг баталгаажуулан, олон улсын нэр хүнд, байр суурийг бэхжүүлсэн, ЗХУ-ын хувьд Алс Дорнодын аюулгүй байдлыг хангаж, хоёр фронтод зэрэг байлдах аюулыг зайлуулсан түүхэн ач холбогдолтой үйл явдал болсон.

Энэхүү түүхэн ялалтын ач холбогдлыг хойч үедээ танин мэдүүлж, архивын эрдэм шинжилгээний үнэ цэнэтэй, шинэ баримтыг судлаачид, олон нийтэд хүргэх зорилгоор хамтарсан үзэсгэлэн зохион байгуулах шийдвэрийг 2019 оны 7 дугаар сарын 15-19-нд Эрхүү хотноо хуралдсан Архивын салбарт хамтран ажиллах Монгол Улс, Оросын Холбооны Улсын Засгийн газрын хоорондын комиссын XXIV хуралдаанаас гаргасан юм.

Хуралдаанаас гаргасан шийдвэрийн дагуу 1939 оны Халхын голын дайны түүхт ялалтын 80 жилийн ойг тохиолдуулан Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Архивын ерөнхий газар, Оросын Холбооны Улсын Холбооны архивын агентлаг зохион байгуулж, Монгол Улсын Батлан хамгаалах яам, Батлан хамгаалахын төв архив, Гадаад харилцааны төв архив, Оросын түүхийн нийгэмлэг хамтран оролцож, “Халхын голын дайн-1939” сэдэвт үзэсгэлэнг гаргаж байна.

Үзэсгэлэнд 1930-аад оны БНМАУ-ын гадаад орчин, Халхын голын дайны үүссэн шалтгаан, эхлэл, өрнөл, төгсгөл, түүхэн ялалт болон үр дагавар, сургамж, БНМАУ, Манжго улсын хилийн шугамыг тогтоосон газрын зураг, хоёр талын болон олон улсын дипломат үйл ажиллагаа, хэлэлцээр, дайны үед явагдаж байсан үзэл суртлын тэмцлийн илрэл болсон фронтын сонин, ухуулах хуудас, түүхэн ялалтыг алдаршуулан мөнхжүүлсэнтэй холбогдох Монгол Улс болон ОХУ-ын архивуудын ховор баримт бичиг, гэрэл зураг, 1940 онд Халхын голын ялалтад зориулан бүтээсэн анхны баримтат киног танилцуулахаар бэлтгэсэн болно.

Монгол Улс, Оросын Холбооны Улсын архивын салбарын нягт хамтын ажиллагааны нэгэн шинэ үр дүн болсон “Халхын гол-1939” үзэсгэлэнг таалан болгооно уу.

Архивын ерөнхий газрын
дарга — С.Энхбаатар

## ПРИВЕТСТВИЕ

Особое место в истории Монгольского народа в борьбе за национальную независимость занимает победа вооруженных сил на реке Халхин-Гол.

В 30-х годах XX столетия углубились геополитические разногласия между существовавшими тогда тремя азиатскими государствами, Китай, Манчжурия и Монголия. В 1935 году Японско-Маньчжурские войска, заняв “Храм Халха” Монгольской Народной Республики, создали приграничный инцидент между МНР и Манжго, а в мае 1939 года Японско-Маньчжурские войска без объявления войны вторглись на территорию МНР, тем самим положили начало войны на реке Халхин-Гол.

Объединенные силы Монголо-Советских войск с 20 по 31 августа 1939 года, взяв в окружение, разгромили 6-ую Квантунскую армию Японии, и одержали историческую победу.

Историческая победа на реке Халхин-Гол укрепила нерушимую дружбу Монгольского и Советского народов, подняла на новый уровень двустороннее сотрудничество между вооружёнными силами двух государств, утвердила национальную независимость МНР, укрепила репутацию и позиции Монголии на международной арене, а в отношении Советского Союза обеспечила его безопасность на Дальнем востоке, устранив опасность ведения боевых действий на два фронта.

На XXIV заседании Межправительственной комиссии, прошедшей в г. Иркутске с 15 по 19 июля 2019 года по вопросам совместного сотрудничества в архивной сфере между правительствами Монголии и России, было принято решение о проведении совместной выставки с целью передачи будущему поколению правдивости и важности этой исторической победы, ознакомления масс с новыми ценными документами исследователей и учёных.

Согласно принятого решения,для празднования 80-ой годовщины победы на реке Халхин-Гол Главное управление архива Монголии совместно с Федеральным архивным агентством Российской Федерации, Министерством обороны Монголии, Центральным архивом Министерства обороны, Центральным архивом иностранных дел и Русским историческим обществом организует выставку “Халхингольская война -1939 год”.

На этой выставке представлены экспонаты, касающиеся внешней политики МНР в 1930-х годах, причин начала войны на реке Халхин-Гол, копии документов о ходе боевых действий и достижении исторической победы, а также её последствий, географическая карта, определяющая границы между МНР и Манчжурской Республикой, экспонаты внешних и дипломатических отношений двух государств, международные соглашения, газеты и боевые листки, в которых показывается как велась агитационная война, а также редкие документы и фотографии из архивов Монголии и Российской Федерации, и сделанный в 1940 году первый докуентальный фильм, посвящённый победе на реке Халхин-Гол.

Желаю всем приятного просмотра выставки “Халхингольская война-1939 год”, которая является новым этапом тесного сотрудничества между архивными агентствами Монголии и России.

Начальник
Главного архивного управления — С.Энхбаатар

## МЭНДЧИЛГЭЭ



Эрхэм хүндэт нөхдөө!

Оросын Холбооны Улсын Холбооны архивын агентлаг, Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Архивын ерөнхий газраас Оросын түүхийн нийгэмлэгийн дэмжлэгтэй зохион байгуулж буй “Халх гол -1939” түүхэн баримтат үзэсгэлэнг зохион байгуулагчид, зочид та бүхэнд мэндчилгээ дэвшүүлье.

Халх голын районы орчим Манжуурын хил дээр болсон зэвсэгт мөргөлдөөнд Зөвлөлт Холбоот Улс ба БНМАУ ялсаны 80 жилийн ойг тохиолдуулан тус үзэсгэлэнг Архивын салбарт хамтран ажиллах Орос-Монголын комиссын үйл ажиллагааны хүрээнд зохион байгуулж байна.

Ажилчин, тариачны улаан арми ба Монголын ардын цэргийн хамтын ажиллагаа, 57 дугаар онцгой корпус, дараа нь 1-р армийн группын командлагчийн албан тушаалд ажиллаж байсан корпус командлан захирагч Г.К.Жуковын үйл ажиллагааг харуулсан Оросын цэргийн түүхийн төв архив, Оросын кино гэрэл зургийн баримтын төв архив болон Монголын Батлан хамгаалахын төв архивын ховор баримт, гэрэл зургуудыг үзэсгэлэндээ дэлгэн үзүүлж байгаа болно.

Дэлхийн стратегийн хувьд онцгой ач холбогдолтой бүс болох Төв Азид ЗСБНХУ ба БНМАУ-ын зэвсэгт хүчний нягт уялдаатай үйл ажиллагааны үр дүнд японы армийн түрэмгийллийг зогсоож чадсан юм. Халхын гол дахь 1939 оны наймдугаар сарын ялалт нь Дэлхийн 2 дугаар дайны эхэнд Япон улс ЗСБНХУ руу довтолохоос татгалзах нэг шалтгаан болсон билээ. Зөвлөлтийн тусламжийн ачаар Монгол Улс өөрийн эрх чөлөө, тусгаар тогтнолоо хамгаалж чадсан бөгөөд хожим нь гитлерийн халдлагын эсрэг тэмцэхэд манай оронд ихээхэн дэмжлэг үзүүлсэн юм.

Орос, монголын архивчдын дэлгэн үзүүлж буй “Халхын гол-1939” түүхэн баримтын энэүзэсгэлэн нь хоёр орны архивын салбарын найрамдалт хэлхээ холбоог хөгжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулж, өргөн олон нийтийн сонирхлыг татах төдийгүй, Орос ба Монгол Улсын шинэ үеийнхэнд бидний нийтийн ялалтын тухай ой санамжийг түүчээлэн хүргэх болно гэдэгт найдаж байна.

Оросын Холбооны Улсын
Холбооны архивын агентлагийн орлогч дарга,
Архивын салбарт хамтран ажиллах Орос-Монголын
комиссын оросын хэсгийн дарга А.В.Юрасов

## ПРИВЕТСТВИЕ

Уважаемые друзья!

Приветствую участников и гостей историко-документальной выставки «Халхин-Гол-1939», организованной Федеральным архивным агентством и Главным архивным управлением Монголии при поддержке Российского исторического общества.

Выставка приурочена к 80-летию победы Советского Союза и Монгольской Народной Республики в вооруженном конфликте на границе с Маньчжурией в районе реки Халхин-Гол и подготовлена в рамках деятельности Российско- Монгольской комиссии по сотрудничеству в области архивов.

В экспозиции представлены уникальные документы Российского государственного военного архива, Центрального архива Министерства обороны Монголии и Российского государственного архива кинофотодокументов, которые отражают ход совместных военных действий РККА и Монгольской народно-революционной армии, деятельность комкора Г.К. Жукова на посту командующего 57-м отдельным корпусом, а затем 1-й армейской группой.

В результате слаженных действий вооруженных сил СССР и МНР было остановлено продвижение японской армии в стратегически важном регионе мира - Центральной Азии. Одержанная в августе 1939 г. победа на Халхин-Голе стала одной из причин отказа Японии от нападения на СССР в начале Второй мировой войны. Монголия, отстоявшая благодаря советской помощи свою свободу и независимость, впоследствии оказала большую поддержку нашей стране в борьбе с гитлеровским нашествием.

Надеюсь, что историко-документальная выставка «Халхин-Гол-1939» российских и монгольских архивистов внесет весомый вклад в развитие дружественных контактов архивных служб двух стран, вызовет интерес широкой общественности, и эстафета памяти о нашей общей победе будет передана новым поколениям граждан России и Монголии.

А. В. Юрасов,
заместитель руководителя
Федерального архивного агентства,
сопредседатель Российско-Монгольской комиссии
по сотрудничеству в области архивов





**1939.09.08.**

- Халх голын дайнд Зөвлөлт, Монголын цэргүүдийг гарамгай удирдсан Г.М.Штерн, Г.К.Жуков нарын зэрэг дарга нарыг “Улаан тугийн одон”-гоор шагнуулахыг хүссэн Ардын Сайд нарын Зөвлөлийн Ерөнхий сайд, маршал Х.Чойбалсангийн 311 тоот бичиг.

*МУУТА, Х-1, Д-2, ХН-725, Х.187*

- Представление Премьер-министра, маршала Х.Чойбалсана в Малый Хурал МНР о награждении Г.М.Штерна, Г.К.Жукова и других орденом Боевого Красного знамени за отличное руководство советско-монгольскими войсками в войне на Халхин-Голе.



**1939.08.10**

- ЗХУ-ын баатар Я.В.Смушкевичийг шагнасан “Цэргийн гавьяаны нэгдүгээр зэргийн одон”-ийн үнэмлэх.

*МУУТА, Х-11, Д-11, ХН-432*

- Удостоверение ордена 1-й степени Боевого Красного знамени МНР, присужденного Герою Советского Союза Я.В.Смушкевича.



**1939.08.10**

- Хязгаарын цэргийн 24 дүгээр отрядын 7 дугаар заставын дарга П.Чогдонг шагнасан цэргийн гавьяаны “Алтан гадас” одонгийн үнэмлэх.

*МУУТА, Х-11, Д-1, ХН-432*

- Удостоверение ордена Боевого Красного знамени МНР, присужденного командиру 7-й заставы 24-го погранотряда П.Чогдону.



**1939.09.28**

- Халхын голын дайнд амь үрэгдсэн дарга, цэргүүдийн дурсгалыг мөнхжүүлж хөшөө босгох тухай МАХЦ-ийн 6 дугаар морьт дивизийн штабын дарга, хошууч Цэрэндашийн тушаал.

*БХТА, Х-1, Д-4, ХН-23, Х.25*

- Приказ начальника штаба 6-й кавдивизии МНРА, майора Цэрэндаши об увековечении памяти павших в войне на Халхин-Голе с установлением памятника.



**1940.03.14**

- Халхын голын баатаруудад зориулсан дурсгалын хөшөө байгуулах тухай Бүх цэргийн жанжны орлогч Ж.Лхагвасүрэнгийн илтгэлийг сонсоод Ардын Сайд нарын Зөвлөлийн 5 дугаар хурлаас гаргасан тогтоол.

*МУУТА, Х-1, Д-2, ХН-765, Х-31*

- Постановление 5-го заседания Совета министров МНР на доклад заместителя Главкома Ж.Лхагвасурена о о сооружении памятника героям Халхин-Гола.



АРХИВЫН ЕРӨНХИЙ ГАЗАР
МОНГОЛ УЛС



**1939.08.12**

- Үйлдвэр, аж ахуйн газар, олон нийтийн байгууллага, ард иргэдээс фронтод илгээх захидал, бэлгийг зохион байгуулах "Тусгай комисс" байгуулах тухай Ардын Сайд нарын Зөвлөлийн Ерөнхий сайд, маршал Х.Чойбалсангийн 95 тоот тушаал.

*МУҮТА, Х-1, Д-2, ХН-721, Х.116-117*

- Приказ №95 Премьер-министра МНР, маршала Х.Чойбалсана о создании "Специальной комиссии" по организации дела отправления писем и подарков, поступавших от промышленных, хозяйственных и общественных организаций и трудящихся аратов.



**1939.09.09**

- Халхын гол дахь цэргийн ангиудын баатарлаг байлдагч нарын хурал дээр Улсын маршал Х.Чойбалсангаас хэлсэн үг. "Ардын үндэсний эрх" сонин.
- Речь маршала Х.Чойбалсана на митинге бойцов и командиров воинских частей МНРА на Халхин-Голе. Газета "Ардын үндэсний эрх".



1939 он.

- Халхын голын фронтын дайчдад туслах бүх нийтийн хөдөлгөөн.
- Всенародное движение помощи бойцам на фронте Халхин-Гола.

**1939.06.13**

- Архангай аймгийн Хашаат сумын 1 дүгээр багийн иргэн 17 настай Ц.Сономжамцаас ахуйн хэрэглээнээсээ илүүчилсэн үхэр тэрэг, тоноглол, бусад зүйлийг МАХЦ-ийн 6 дугаар дивизийн 17 дугаар хороонд бэлэглэхийг хүсч, БНМАУ-ын Ерөнхий сайд Х.Чойбалсанд бичсэн захидал.

*МУҮТА, Х-1, Д-2, ХН-726, Х.179*

- Письмо арата 1-го бага Хашаат сомона Архангайского аймака, 17 летнего Ц.Сономжамца Премьер-министру МНР, маршалу Х.Чойбалсану о желании подарить лишние от собственного потребления повозки, снаряжения и прочие предметы 17 полку 6-й кавдивизии МНРА.







- Манжго улсын эзэн хаан Пу И
- Император государство Манж-го Пу И



- Манжго улсын нийслэл Шиньжин хот. 1937 он
- Столица государства Манж-го город Шиньжин. 1937 год








**1927.07.25**

- Генерал Танака Японы эзэн хаанд "Дэлхийд ноёрхлоо тогтоохын тулд эхлээд Манжуур, Монгол, Хятадыг эрхшээлдээ оруулах хэрэгтэй" гэсэн утга бүхий бичиг өргөжээ. Зураг дээр: Генерал Танака, "Танакагийн меморандум"
- Генерал Танака императору Японии представил письмо со следующим содержанием: "Для того, чтобы господствовать над миром необходимо сначала взять под своим влиянием Манжурию, Монголию и Китай" На рисунке Генерал Танака, "Меморандум Танаки"






**1939.03.05**

- Дорнод аймгийн Буйр нуур сумын "Халхын сүм" хэмээх Гандангчойнхордашпилжэйлин хийдийн лам нараас уг хийдийг өөрийн улсад буцаан авч, амар тайван амьдруулахыг хүсч Засгийн газарт өргөсөн бичиг.

*ГХТА. Х-117, Д-1, ХН-17*

- Письмо представленное Правительству от лам буддиских монах так называемый "Халхин сумэ" Буйр нуур сомона Восточного аймака, который называется манастыр Гандангчойнхордашпилжэйлин с просьбой возвращить своему государству того манастыря, мирного жительства.



АРХИВЫН ЕРӨНХИЙ ГАЗАР МОНГОЛ УЛС



**1935.06.14**

- БНМАУ-ын хил хязгаарыг удаа дараа зөрчиж байгаа нь үл зохилдох хэрэг тул харьяат газрын харуулд сайтар зааварлан сургаж, хил хязгаарыг амгалан тайван байлгахыг хүсч ГЯЯ-ны сайд П.Гэндэнгээс Манжго улсын Гадаад яамны сайдад илгээсэн ноот.

*ГХТА. Х-117, Д-1, ХН-2*

- От министра иностранных дел П. Гендена направленный министру иностранных дел государства Манж-го нот с пожеланиями неоднократное нарушение границы МНР является недопустимим делом, поэтому хорошенко обучать и инструктировать подведомственного караула, на границе соблюдать спокойствие и мир.



- БНМАУ-ын баатар Ш.Гонгор /1936.01.29/
- Герой МНР Ш. Гонгор



- БНМАУ-ын баатар Д.Дэмбэрэл /1936.04.07/
- Герой МНР Д. Демберел



- Хязгаарын цэргийн 24 дүгээр отрядын 7 дугаар заставын дарга, БНМАУ-ын баатар П.Чогдон /1971.03.12/ заставын зарим байлдагчдын хамт.
- Начальник 7-ого застава 24-ого отряда пограничных войск, герой МНР П. Чогдон /1971.03.12/ вмесме с некоторыми солдатами.



**1939.05.18**

- Манжго улсын Засгийн газраас хилийн будлианы талаар удаа дараа гүтгэсэн ноот бичиг ирүүлж байгааг өөрийн Засгийн газарт мэдэгдэж, Манжго улсын Засгийн газарт хандан хатуу эсэргүүцэл гаргахыг хүсч, БНМАУ-ын ГЯЯ-ны сайд Х.Чойбалсангаас ЗСБНХУ-аас БНМАУ-д суугаа Элчин сайдад илгээсэн ноот.

*ГХТА. Х-2, Д-3, ХН-32*

- Нот министра Иностранных Дел МНР Х. Чойбалсана послу СССР в МНР с просьбой сообщить своему правительству о том, что правительство государства Манж-го по поводу пограничных инцидентах неоднократно присылает клеветнический нот и правительству госдарства Манж-го обращаться с твердым протестом.





**1939.05.24**

- Дорнод хязгаарт Японы түрэмгийлэгчтэй баатарлагаар байлдаж амь үрэгдсэн, шархадсан байлдагч, дарга нарын ар гэр болон биесэд тусламж үзүүлэх "Тусгай комисс" байгуулах тухай Ардын Сайд нарын Зөвлөлийн Ерөнхий сайд, маршал Х.Чойбалсангийн 59 тоот тушаал.

*МУУТА, Х-1, Д-2, ХН-726, Х.15*

- Приказ №59 Премьер-министра МНР, маршала Х.Чойбалсана о создании "Специальной комиссии" по оказанию помощи раненым и семьям погибших бойцов и командиров, героически сражавшихся в боях с японскими агрессорами на восточных рубежах страны.



**1939.06.06**

- Улаанбаатар хотын үйлдвэр, хоршоодын худалдааны байгууллагаас Тамсагбулаг дахь МАХЦ-ийн 6 дугаар морьт дивизийн дайчдад баяр хүргэж, бэлэг явуулсан тухай захидал.

*БХТА, Х-1, Д-4, ХН-23, Х.4-5*

- Письмо от работников промышленных предприятий и торговых кооперативов г. Улан-Батор бойцам 6-й кавдивизии МНРА в Тамцагбулаке с поздравлением и об отправлении подарков.



**1939.09.01**

- ДЯЯ-ны төв дэх ХЗЭ-ийн байгууллага ба бүх гишүүдээс МАХЦ-ийн 6 дугаар морьт дивизэтэй шефийн холбоо тогтоож, баяр хүргэсэн тухай бичиг.

*БХТА, Х-1, Д-4, ХН-23, Х.7*

- Послание ревсомольских организаций и ревсомольцев при МВД бойцам 6-й кавдивизии МНРА об установлении шефства.



**1939.09.02**

- МАХЦ-ийн хээрийн штабаас Улаанбаатар хотын нам, эвлэл, үйлдвэрийн газрын улс орныг батлан хамгаалахын идэвхтэн гишүүдэд явуулсан талархлын бичиг.

*БХТА, Х-1, Д-4, ХН-23, Х.71-72*

- Благодартвенное письмо Полевого штаба МНРА активистам Совета обороны при партийных, ревсомольских организациях и промышленных предприятиях



АРХИВЫН ЕРӨНХИЙ ГАЗАР МОНГОЛ УЛС



**1939.11.27**

- БНМАУ ба Манжго улсын хилийг тогтоох хуралд ЗСБНХУ болон БНМАУ-ын Засгийн газраас томилогдсон төлөөлөгчдийн төлөвлөгөө. /маш нууц/

*ГХТА. Х-117, Д-1, ХН-45*

- План делегации назначенной правительствами СССР и МНР по установлению государственной границы МНР и Манж-го. /совершенно секретно/





**1940.06.09.**

- 1939 оны 9 сард гал зогсоох хэлэлцээний үед хэрэглэж байсан 200.000-ын газрын зургийг үндэслэн байгуулсан БНМАУ ба Манжго-гийн хоорондох хил хязгаарыг нарийвчлан тогтоох тухай хэлэлцээр.

*ГХТА. Х-2, Д-3, ХН-32*

- Соглашение детализированного установления границ между МНР и Манж-го на основе топографической карты масштаба 200,000 используемой во время переговоров по прекращения огня в сентября 1939 года.



**1940 оны 1 дүгээр сар**

- БНМАУ-ын төлөөлөгч Л.Жамсранг угтан авч буй нь.
- Встреча представителя МНР Л. Жамсрана.



**1940 оны 1 дүгээр сар**

- Хил тогтоох хамтарсан комиссын хуралдаан.

*ГХТА. Х-117, Д-1, ХН-2*

- Заседание совместной комиссии по установлению границ.



**1940.06.09.**

- Дорнод хилийн асуудлыг амжилттай шийдвэрлэсэн явдалд талархал илэрхийлж, Х.Чойбалсан, Ю.Цэдэнбал нараас И.В.Сталинд илгээсэн цахилгаан мэдээ.

*ГХТА. Х-2, Д-3, ХН-32*

- Телеграмма Х.Чойбалсана и Ю.Цеденбала направленная Сталину в котором выразили благодарность в связи успешного решения вопроса восточной границы.





**1935.06.03**

- БНМАУ, Манжго улсын хилийн будлианы зохицуулах бага хурлын төлөөлөгчид /Зүүн гар талаас: Манжго улсын Гадаад яамны Улс төрийн хэлтсийн дарга Канки, Хянган хойд мужийн цэргийн сайд, генерал Үржин Гармаев, Хянган мужийн захирагч Линь Шэн, БНМАУ-ын төлөөлөгчдийн дарга Г.Самбуу, гишүүн Д.Догсом, Г.Дамба нар/.

*ГХТА. Х-117, Д-1, ХН-3*

- Делегация конференции регулировки пограничных инцидентов МНР и Манж-го. /Слева начальник Политического отдела Министерства внешных отношений государства Манж-го Канки, военный министр северной области Хянгана, генерал Үржин Гармаев, управляющий Хянганской области Линь Шэн, председатель делегации МНР Г. Самбуу, члены делегации Д. Догсом, Г. Дамба/



**1935.06.03**

- БНМАУ, Манжго улсын хилийн будлианыг зохицуулах бага хурлын анхдугаар хуралдааны тэмдэглэл.

*ГХТА. Х-117, Д-1, ХН-63*

- Запись первого заседания конференции регулировки пограничных инцидентов МНР и Манж-го.







**1936.06 сар.**

- Хурлын төлөөлөгчид хүлээн авалт дээр.

*ГХТА. Х-117, Д-1, ХН-3*

- Делегация конференции на приеме..
- ЗХУ-ын Чита хотноо суугаа Манжго улсын консулаас БНМАУ-ын ГЯЯ-нд ирүүлсэн бичгийн дугтуй. 1935 он.

*ГХТА. Х-117, Д-1, ХН-2*

- Конверт письма присланного министерству Иностранных Дел МНР от консула государства Манж-го в городе Чита Советского Союза. 1935 г.



**1935.06.03**

- БНМАУ, Манжго улсын хилийн будлианыг зохицуулах бага хурлын анхдугаар хуралдаанд хэлэлцэж тогтсон асуудлын талаар төлөөлөгчдийн дарга Г.Самбуугаас ГЯЯ-ны орлогч сайд М.Дугаржавт ирүүлсэн мэдээ.

*ГХТА. Х-117, Д-1, ХН-10*

- Сообщение от председателя делегации Г. Самбуу о согласованных вопросах на первом заседании конференции регулировки пограничных инцидентов МНР и Манж-го, присланное заместителю министра Иностранных Дел М.Дугаржаву.



АРХИВЫН ЕРӨНХИЙ ГАЗАР
МОНГОЛ УЛС





### 1936.03.01

- БХК(б)Н-ын Төв Хорооны нарийн бичгийн дарга И.В.Сталин "Хэрэв Япон улс БНМАУ-ын тусгаар тогтнолд халдан довтлох аваас бид БНМАУ-д туслана" гэдэг мэдэгдэл хийсэн.
- Секратарь Центрального Комитета ВСК(б)П И.В.Сталин сделал заявление, о том что "если Япония будет посягнуть на независимость МНР, то мы поможем МНР" .

### 1936.03.12

- "БНМАУ, ЗСБНХУ-ын хооронд харилцан туслалцах тухай протокол" /монгол, орос хэлээр/.
- Протокол о взаимопомощи между МНР и СССР /на монгольском и русском якыках/ .



### 1939.05.16

- 1939 оны 5 дугаар сарын 11-16-ны өдрүүдэд БНМАУ-ын Халхын гол дахь хилийн отрядын хариуцсан хэсэгт Япон, Баргын цэрэг өдөөн хатгасан тухай БНМАУ-ын Дотоодын цэргийн ерөнхий зөвлөхийн орлогч Подосеновын танилцуулах бичиг.
- Докладная записка зам. главного инструктора войск МВД МНР Подосенова о провокациях японцев и японо-баргут на участке Халхингольского погранотряда МНР в период с 11 по 16 мая 1939 г.

*РГВА. Ф. 32113. Оп. 1. Д. 203. Л. 3–5.*




### 1939.05.26

- Монголын морин цэргийн 6-р дивиз ба АТУА-ийн 11-р танкийн бригадын байршлын схем.
- Схема расположения частей 6-й монгольской кавалерийской дивизии и сводного отряда стрелково-пулеметного батальона 11-й легкой танковой бригады РККА. .

*РГВА. Ф. 32113. Оп. 1. Д. 204. Л. 314.*





№ 9

ПРЕМЬЕР-МИНИСТРУ МНР

МАРШАЛУ ЧОЙБАЛСАНУ.

Представляем копию Протокола на поворотные пункты границы, подписанного на совместном заседании Делегаций МНР и Манчжоу-Го в г.Чите 14-го июня 1941 года.

К протоколу прилагается карта масштаба 1:100 000, как вспомогательная к договорной карте.

ПРИЛОЖЕНИЕ: Копия протокола на "5" лист.
Карта " " лист.

Доржи

ПОЛКОВНИК:

### 1941.06.14.

- БНМАУ ба Манжго улсын хил тогтоох хамтарсан комиссын БНМАУ-ын Засгийн газрын Бүрэн эрхэт төлөөлөгчдөөс хилийн шугам тогтоосон хуралдааны протоколыг маршал Х.Чойбалсанд явуулсан тухай албан бичиг.

*ГХТА. Х-117, Д-1, ХН-51*

Официальное письмо присыланное маршалу Х.Чойбалсану протокола заседания полномочным представителем Правительства МНР совместной комиссии по установлению государственной границы МНР и Манж-го по установлению пограничной линии.



Копия.

ПРОТОКОЛ
ЗАСЕДАНИЯ СМЕШАННОЙ КОМИССИИ ПО УТОЧНЕНИЮ ГРАНИЦЫ НА МЕСТНОСТИ МЕЖДУ МОНГОЛЬСКОЙ НАРОДНОЙ РЕСПУБЛИКОЙ И МАНЧЖОУ-ГО В РАЙОНЕ КОНФЛИКТА 1939 ГОДА.

Заседание открылось в г. Чите в 10 часов утра 14-го июня по летоисчислению МНР ( 8 года Кандэ).

Председательствует: Уполномоченный Правительства Манчжоу-Го г-н СИМОМУРА.

Присутствовали:

От Монгольской Народной Республики:

Уполномоченные Правительства Монгольской Народной Республики - ДОРЖИ
- СМИРНОВ

Вспомогательные члены: КОГАН И.Я., ТОМИЛИН Н.И., МОТИНОВ П.С., КУДРОВ К.П., МАКСИМОВ А.К., ГРИГОРЬЕВ Н.А., РУНОВ Ф.И., КОРОБОЧКИН А.П., ПЕТРОВ И.Г.

От Манчжоу-Го:

Уполномоченные Правительства Манчжоу-Го - СИМОМУРА НОБУСАДО
- БУИНМАНТО

Вспомогательные члены: САЙТО КОЗОО, СИМА ИОСИ, ГИОТОКУ КУНИДЗИРО, ООМОРИ МАТАКИЧИ, УУНДАРАЙ, УЕНО МАСАО, ОГИНО ИОСИТО

Руководствуясь Соглашением МОЛОТОВ-ТОГО от 9-го июня 1940 года и приложенной к нему договорной картой 1:200000 и исходя из опыта работы Смешанной Комиссии, проведенной ею в 1940 году на местности, Уполномоченные Правительств Монгольской Народной Республики и Манчжоу-Го в результате совещаний, проходивших между ними в г. Чите с 28-го мая по 14-е июня



- 1939 онд маргаантай байсан бүсэд БНМАУ ба Манжго улсын хоорондох 1939 оны маргаантай байсан бүс газрын хилийг нарийвчлан тогтоосон зураг
- Карта с уточненным местоположением точек углов поворота границы и похождением линии границы между МНР и Маньчжоу-Го в районе конфликта 1939 г.



АРХИВЫН ЕРӨНХИЙ ГАЗАР
МОНГОЛ УЛС






**1941.11.29.**

- БНМАУ, Манжго улсын хилийг тогтоож төгссөн тухай асуудлыг хэлэлцээд Ардын Сайд нарын Зөвлөлийн 56 дугаар хурлаас гаргасан тогтоол. /нууц/ 1941.11.29.

*ГХТА. Х-117, Д-1, ХН-46*

- Постановление 56-го заседания Народного Совета Министров обсуждавшего вопрос об окончании установлений государственной границы между МНР и Манж-го. /секретно/



**1940 он**

- ЗСБНХУ ба Япон улс Төвийг сахих гэрээнд гарын үсэг зурж буй нь.
- Подписание договора нейтралитата СССР и Японии.





**1939.05.21**

- Гадаад Монгол (БНМАУ)-ын цэргийг Номон Хан-Бүрд овоо (Халхын гол)-д устгах тухай Японы 23-р явган цэргийн дивизийн дарга, дэслэгч генерал М.Комацубарын тушаал.
- Приказ командира 23-й японской пехотной дивизии генерал-лейтенанта М. Комацубары об уничтожении войск Внешней Монголии (МНР) в районе Номон-Хан-Бурд-Обо (Халхин-Гол).

*РГВА. Ф. 32113. Оп. 1. Д. 4. Л. 5–6 (Перевод с японского языка, современный оригиналу).*



- Квантуны армийн 23-р явган дивизийн захирагч, дэслэгч генерал Мичитаро Комацубара

*МУҮТА. КГЗДАБА, Х-115*

- Командующий 23-ой пехотной дивизии Квантунской армии, лейтенант генерал Мичитаро Комацубаро



- 1939.05.28-29-ний өдрийн байлдааны зураг
- Карта боевых действий за 28-29 мая 1939 г.



**1939 он.**

- Монгол ардын хувьсгалт армийн пулёметчид тэргүүн эгнээнд. Монгол, Халхын гол.

*Зурагчин В.А.Темин.*

- Пулеметчики Монгольской народной революционной армии на передовой. Монголия, район р. Халхин-Гол. Фотограф В.А.Темин.

*РГАКФД. Арх. № 0-358937.*



АРХИВЫН ЕРӨНХИЙ ГАЗАР МОНГОЛ УЛС



**1939 он.**

- Шархадсан улаан армийн цэргүүдийг эмнэлэг рүү агаарын тээврээр илгээж буй нь. Монгол Улс. Халх гол. Зургийг В.А. Темин.
- Отправка раненных красноармейцев на лечение в госпиталь авиационным транспортом. Монголия, район р. Халхин-Гол. Фотограф В.А. Темин.

*РГАКФД. Арх. № 0-366518.*



**1939.07.30**

- ЦЯЯ-ны сайд, Бүх цэргийн жанжны орлогч бөгөөд Улс төрийн газрын дарга, корпусын комиссар Ж.Лхагвасүрэнгээс “Халхын гол ба Хайлаастайн гол нь БНМАУ-ын нутаг мөн болох тухай” харьяа ангийн дарга, комиссар нарт явуулсан бичиг.

*БХТА Х-1. Д-4. Хн-19. хуудас 10.*

- Письмо Министра Военных дел, начальника Политического Совета и заместителя Верховного Главнокомандующего Монгольской Народно-Революционной Армии Ж.Лхагвасурэн, направленное командирам и комиссарам подчиненных войсковых частей “О том, что Халхин-Гол и Хайлаастайн гол являются территорией МНР”.





**1939 он.**

- БНМАУ-аас Баргын цэргүүдэд хандаж гаргасан ухуулах хуудас.

*БХТА Х-1. Д-4. Хн-34. хуудас 2.*

- Агитационные листы с обращением МНР к Барга войскам

- МАХЦ-ийн 6 дугаар морьт дивизийн 17 дугаар морьт хорооноос фронт дээр гаргаж байсан “Улаан атак” сонин.

*БХТА Х-1. Д-4. Хн-37. хуудас 3.*

- Информация о сражениях, предназначенных для опубликования на газете “Атака удалых бойцов”


К БОЙЦАМ-ГЕРОЯМ СССР
на монгольской границе!

**1939.05 сар.**

- АТУА-ийн дарга асан П.И.Дудко-гийн нэрийн өмнөөс АТУА-ийн байлдагчдад хандаж бууж өгөх тухай “Монголын хил дээрх ЗСБНХУ-ын баатар цэрэг нарт” гэсэн японы ухуулах хуудас.
- Японская листовка «К бойцам-героям СССР на монгольской границе!» с призывом к бойцам РККА от имени бывшего командира РККА П.И. Дудко сдаваться в плен.

*РГВА. Ф. 9. Оп. 39. Д. 84. Л. 184–184 об.*





**1939 оны зун**

- Армийн 1-р бүлгийн Цэргийн зөвлөлийн гишүүн, корпусын комиссар Н.И.Бирюков, Ажилчин тариачны улаан армийн агаарын хүчний командлагчийн орлогч, Армийн 1-р бүлгийн агаарын хүчний командлагч, корпус захирагч Я.В.Смушкевич ба Армийн 1-р бүлгийн командлагч, корпус захирагч Г.К.Жуков нар /зүүн гар талаас/. Монгол улс, Халх гол.
- Член военного совета 1-й армейской группы корпусной комиссар Н.И. Бирюков, заместитель начальника ВВС РККА командующий авиацией 1-й армейской группы комкор Я.В. Смушкевич и командующий 1-й армейской группой комкор Г.К. Жуков (слева направо). Монголия, район р. Халхин-Гол.

*РГВА. Ф. 40892. Оп. 1. Д. 21. Л. 14*



**1939 он.**

- Зөвлөлтийн нисгэгчид байлдааны нислэгийн дараа. Монгол, Халхын гол. Зурагчин В.А.Темин.
- Советские летчики после боевого вылета. Монголия, район р. Халхин-Гол. Фотограф В.А. Темин.

*РГАКФД. Арх. № 0-366421.*





**1939.07.15**

- Японы нисэх онгоцууд Тамсагбулаг, Чойбалсан хотыг бөмбөгдөхөд учирсан хохирлын акт.

*БХТА Х-1. Д-4. Хн-39. хуудас 20.*

- Акт об ущербе, причиненном при бомбардировке японскими самолетами Тамсагбулага и города Чойбалсан.

**1939 он.**

- Зөвлөлтийн цэргүүд Японы унасан онгоцыг үзэж байна. Монгол, Халхын гол. Зурагчин С.Гурарий.
- Советские бойцы осматривают сбитый японский самолет. Монголия, район р. Халхин-Гол. Фотограф С. Гурарий.

*РГАКФД. Арх. № 0-251901а.*



АРХИВЫН ЕРӨНХИЙ ГАЗАР МОНГОЛ УЛС





• Халхын голын баруун эргийн Баянцагааны нуруунд 1939 оны 7 дугаар сарын 2-5-ны өдрүүдэд болсон байлдааны зураг.

• Бои в местности Баянцаган, на левом берегу Халхин-гола. 2-5 июля 1939 г.

**1939.07.26**

• ЦЯЯ-ны сайд, Бүх цэргийн жанжны орлогч бөгөөд Улс төрийн газрын дарга корпусын комиссар Ж.Лхагвасүрэнгээс 1939 оны 7 дугаар сарын 1-26 хүртэлх хугацаанд явуулсан байлдааны тухай ЦЯЯ-ны сайд, Бүх цэргийн жанжин, маршал Х.Чойбалсанд илтгэсэн рапорт.

*БХТА Х-1. Д-4. Хн-19. хуудас 3-9.*

• Рапорт Министра Военных дел (Военного Министра), Начальника Политического Совета и заместителя Верховного Главнокомандующего Монгольской Народно-Революционной Армии Ж.Лхагвасурэн о боевых действиях на период 1 июля по 26 июля 1939 года, представленному Министру Военных дел, Верховному Главнокомандующему, маршалу Чойбалсану.



**1939 он**

• МАХЦ-ийн морин атак.

*МУУТА. КГЗДАБА, Х-115*

• Атаки кавалеристов конных дивизий МНРА.



**1939.07.25**

• Дайсны байрлал болон олзолсон зүйлсийн талаар МАХЦ-ийн 8 дугаар морьт дивизийн штабын дарга Дашдоржийн бичсэн байлдааны мэдээ.

*БХТА Х-1. Д-4. Хн-32. хуудас 38.*

• Военный доклад- сообщение начальника штаба 8-ой кавалерийской дивизии Дашдоржа о расположении врага и о захваченных во время сражения вещах.



**1939.08.07**

• МАХЦ-ийн 6 дугаар морьт дивизийн хориглолтын зураг.

*БХТА Х-1. Д-4. Хн-32. хуудас 22.*

• Фото об отражении нападения 6-ой кавалерийской дивизии.







**1939.08.26**

• Бүслэгдсэн дайсныг устгах ба БНМАУ-ын хилийг хамгаалах тухай Армийн 1-р бүлгийн бие бүрэлдэхүүнд зориулсан байлдааны тушаал.

• Боевой приказ войскам 1-й армейской группы об уничтожении окруженного противника и охране государственной границы МНР.

*РГВА. Ф. 32113. Оп. 1. Д. 3. Л. 76–77*

**1939 он**

• Армийн 1-р бүлгийн командлагч, корпус захирагч Г.К.Жуков олзолсон зэр зэвсэгтэй танилцаж буй нь. Монгол улс, Халх гол, Зургийг В.А. Темин.

• Командующий 1-й армейской группой комкор Г.К. Жуков во время осмотра трофейных боеприпасов. Монголия, район р. Халхин-Гол. Фотограф В.А. Темин.

*РГАКФД. Арх. № 0-366601.*





ЛИКВИДАЦИЯ ОСТАТКОВ ЯПОНО-МАНЧЖУРСКИХ ВОЙСК В ПРИГРАНИЧНОЙ ПОЛОСЕ МНР

**1939.09.01**

• 1939 оны 8-р сарын 5-17-ны өдрүүдэд болсон Халх голын тулалдааны явц ба дайтаж буй талуудын амьд хүч, техникийн хохирлын тухай "БНМАУ-ын хил дотор Япон-Манжго-гийн цэргийн үлдэгдлийг устгав" хэмээх ТАСС-ын мэдээ.

• Сообщение ТАСС «Ликвидация остатков японо-маньчжурских войск в приграничной полосе МНР» – о ходе боев в районе р. Халхин-Гол с 5 по 17 августа 1939 г. и потерях в живой силе и боевой технике противоборствующих сторон.

*РГВА. Ф. 33987. Оп. 3а. Д. 1217. Л. 137 (2)*

• 1939 оны 8-р сарын 20-31-ний өдрийн хоорондох Армийн 1-р бүлгийн сөнөөгч онгоцны эскадрилийн нислэгийн бүдүүвч зураг.

• Карты-схемы действий истребительной авиации 1-й армейской группы с 20 по 31 августа 1939 г. 20 августа 1939 г.

*РГВА. Ф. 32113. Оп. 1. Д. 247. Л. 10*



АРХИВЫН ЕРӨНХИЙ ГАЗАР МОНГОЛ УЛС